



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/77

Баян-Адарга сум

**Байгалийн баялаг ашиглах,
нөхөн сэргээх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын журам батлах тухай 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын төвд барих 2,82км хатуу хучилттай авто зам барихад ашиглах шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглаж техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж орон нутагт хүлээлгэн өгөхийг Их Хайрханы Харгуй ХХК-ийн захирал (А.Азжаргал)-д даалгасугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах газрын байршлын солбицол зургийг хавсралтаар баталсугай.

3. Карьерыг ашиглах явцад байнгын хяналт тавьж түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж зам барилгын ажил дуусмагц нөхөн сэргээлтийг хийлгэж талбайг хүлээн авахыг Баян-Адарга сумын татварын байцаагч (О.Жаргалцэцэг), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ц.Цэрэндулам) нарт үүрэг болгосугай.

~~ЗАСАГ ДАРГА~~  ~~ОЛХАГВАДОРЖ~~

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 15 ны өдрийн 1/19 тоот захирамжийн хавсралт



Түгээмэл тархацтай ашигт малтмалын цэгийн солбицол, байршлын зураг

№	Газрын зориулалт	Солбицол		Талбайн хэмжээ
		N	E	5га
1	Түгээмэл тархацтай ашигт малтмал	48.324493	111.06004	
		48.3251.03	111.060608	
		48.324625	111.061579	
		48.324054	111.061018	